



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 565

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорноговь-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн нийт 7,760,000.00 (долоон сая долоон зуун жаран мянга) төгрөгийн балансын үнэ, 4,542,222.23 (дөрвөн сая таван зуун дөчин хоёр мянга хоёр зуун хорин хоёр төгрөг хорин гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. "Дорноговь-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Загдраднаа, гүйцэтгэх захирал А.Баттогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006912

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн
56 дугаар тогтоолын хавсралт

**"Дорноговь-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар
худалдах хөрөнгийн жагсаалт**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэр лэсэн ашиглалт ад орсон он	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Хьюндай маяги маркийн 43-63 ДГО улсын дугаартай, ачааны автомашин, Арлын дугаар- КМFGA17FPTC114755	1996/ 2018	4,960,000.00	3,375,555.56	1,584,444.44	1,600,000.00
2	Хьюндай маркийн 02- 98 ДГО улсын дугаартай, микроавтобус, Арлын дугаар - КМJWWN7HP5U663596	2005/ 2019	2,800,000.00	1,166,666.67	1,633,333.33	2,000,000.00
	ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН		7,760,000.00 (долоон сая долоон зуун жаран мянга)	4,542,222.23 (дөрвөн сая таван зуун дөчин хоёр мянга хоёр зуун хорин хоёр төгрөг хорин гурван мөнгө)	3,217,777.77 (гурван сая хоёр зуун арван долоон мянга долоон зуун далан долоон төгрөг далан долоон мөнгө)	3,600,000.00 (гурван сая зургаан зуун мянган)